



НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ  
ГАЗРЫН ДАРГА Д.ЗОРИГТ ТАНАА

## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:62-26-32-30  
E-mail: info@audit.gov.mn

2018.02.23 № 06/453  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Зөрчилгүй санал дүгнэлт

Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2017 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагын мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

## Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ  
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ



## 2 АУДИТЫН ТАЙЛАН

### 2.1 Оршил

Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайланг Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга Д.Зоригт танд танилцуулж байна.

Энэхүү тайланд танай байгууллагын санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулан Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын системд оруулсан бөгөөд аудитад баримталсан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

### 2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аудитыг Төрийн аудитын тухай, Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.


Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан төрийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018 оны 2 дугаар сарын 5-наас 2018 оны 2 дугаар сарын 19-ны хооронд хийж, аудитын тайланг 2018 оны 2 дугаар сарын 23-нд эцэслэн баталгаажуулж, Төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Г.Жавхлан хариуцаж хэрэгжүүлэв.

Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Нийгмийн даатгалын ерөнхий газраас 2018 оны 1 дүгээр сарын 26-ны өдрийн 175 дугаар албан бичгээр Үндэсний аудитын газарт хүргүүлэхээр байсан боловч Төсвийн тухай хуульд заасан цаглабарт хугацаанаас 4 хоноогоор хожимдуулан 2018 оны 1 дүгээр сарын 29-ний өдөр ирүүлсэн байна.





### 2.3 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Нийгмийн даатгалын ерөнхий газрын санхүүгийн үйл ажиллагаандаа Монгол Улсын Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай болон бусад холбогдох хуулиуд, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, санхүүгийн тайлан, тодруулгын маягт, санхүүгийн тайлан бэлтгэж гаргах аргачлал, “Эдийн засгийн ангилал батлах тухай” зэрэг эрх зүйн актуудыг мөрдөж байна.

НДЕГ нь “Бид даатгуулагчийнхаа итгэл найдвар, сэтгэл ханамжаар үнэлэгдэх нийгмийн даатгалын үйлчилгээг хүргэнэ” гэсэн зорилго дэвшүүлэн үйл ажиллагаагаа явуулж байна.

Мөн “Нийгмийн даатгалын байгууллага нь өсөн дэвших эрмэлзэлтэй мэргэшсэн, чадварлаг, ёс зүйтэй хүний нөөцөд түшиглэн үйл ажиллагаагаа цаг үргэлжид сайжруулан, түншлэл хамтын ажиллагааг дэмжин, харилцан үр ашигтай хамтран ажиллаж, сайн засаглалыг хэрэгжүүлэн хэрэгцээ шаардлагад нийцсэн чанартай үйлчилгээг ДААТГУУЛАГЧДАД хүргэнэ” гэсэн чанарын бодлоготойгоор ажиллаж байна.

Нийгмийн даатгалын ерөнхий газрын үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд төлөвлөсөн хэмжээнд судалж, баримтжуулсан.

### 2.4 Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудит хийхэд Аудитын олон улсын стандарт, Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000 – 1810 буюу Санхүүгийн аудитын удирдамж, Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

Аудитаар Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санал дүгнэлт өгөх зорилгоор тэдний бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн дансдын уламжлалт болон хяналтын эрсдэлийг үнэлж баримтжууллаа.

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын 6 чиглэлээр түүвэрчилсэн байдлаар аудитын 24 горим, сорил гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Эдгээр горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн алдаа, зөрчилтэй зарим гол асуудлыг энэ тайлангийн 2.9 дэх заалтад хураангуйлан тэмдэглэв.

Нийгмийн даатгалын ерөнхий газрын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд эрсдэл бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтний оролцоо шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ.

Нийгмийн даатгалын ерөнхий газар нь санхүүгийн тайлангаа салбарын хэмжээнд өөрийн боловсруулсан нягтлан бодох бүртгэлийн програм хангамжаар бэлтгэсэн байна.

### 2.5 Дотоод хяналт

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Нийгмийн даатгалын ерөнхий газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт хангалттай хэмжээнд хэрэгжиж байна гэж үзлээ.



## 2.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2017 оны зардлын 2,932,361.3 мянган төгрөгийн батлагдсан төсвөөс 2,928,560.2 мянган төгрөг зарцуулж 3,801.1 мянган төгрөгийг хэмнэсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэлийн талаарх зарим мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 2,928,560.2 мянган төгрөг буюу 99.87 хувьтай байгаа нь бичиг хэргийн зардал, багаж хэрэгслийн зардлуудыг хэмнэж ажилласнаас шалтгаалсан байна.

## 2.7 Шилэн дансны мэдээлэл

Нийгмийн даатгалын ерөнхий газар нь байгууллагын [www.ndaatgal.mn](http://www.ndaatgal.mn) веб хуудаст шилэн дансны цэсийг холбосон ба Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллаж цалингийн зардлаас бусад 5,000.0 мянган төгрөгөөс дээш 28 ажил гүйлгээг оруулахаас бүрэн оруулж ажилласан байна.

## 2.8 Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 6 чиглэлээр эрсдэл тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 24 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Хэрэгжүүлсэн горим сорилын үр дүнг гүйцэтгэлийн үе шатны "Төлөвлөсөн горим, сорилуудыг хэрэгжүүлж, үр дүнг аудитын чиглэл тус бүрээр баримтжуулах" гэсэн үе шатны ажилд хамааруулан ТАБ-СТА-В-3 маягтаар данс тус бүрээр баримтжуулсан болно.

Дээрх горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн зарим зөрчилтэй асуудлыг энэ тайлангийн 2.9-д хураангуйлан тэмдэглэв.

## 2.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

### 2.9.1 Төсвийн тухай хуулийн цаглабарт хугацаа

НДЕГ-ын удирдлага нь 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг 2018 оны 01 дүгээр сарын 26 өдрийн 175 дугаартай албан бичгээр Үндэсний аудитын газарт хүргүүлсэн ба хуулийн хугацааг нийт 4 хоногоор хоцроосон нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д "...жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн санхүүгийн тайланг 02 дугаар сарын 25-ны дотор харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэх" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн удирдлагад жилийн эцсийн санхүүгийн тайланг Төсвийн тухай хуулийн цаглабарт хугацаанаас хоцроож ҮАГ-т хүргүүлсэн нягтлан бодогч П.Адъяасүрэнд арга хэмжээ авах тухай албан шаардлага хүргүүлэх;

### 2.9.2 Төсвийн гүйцэтгэлийн талаар

НДЕГ нь тайлант онд 2,932,361.3 мянган төгрөгийн батлагдсан төсвөөс 2,928,560.2 мянган төгрөг зарцуулж батлагдсан төсвийг нийт дүнгээр нь хэтрүүлээгүй боловч цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлыг 647.6 мянган төгрөгөөр, гэрэл цахилгааны зардлыг 399.1 мянган төгрөгөөр, түлш халаалтын зардлыг 967.4 мянган төгрөгөөр, бичиг хэргийн зардлыг 2,246.6 мянган төгрөгөөр, БҮТЭЗ-ийн зардлыг 3,890.2 мянган төгрөгөөр, урсгал засварын зардлыг 8,077.7 мянган төгрөгөөр тус тус хэтрүүлэн зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэж заасныг хэрэгжүүлэн ажиллаж батлагдсан төсвийн ангиллыг хэтрүүлэхгүй байх талаар менежментийн захидлаар аудитын зөвлөмж өгөх;



### 2.9.3 Авлагын талаар

НДЕГ-ын удирдлага 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд түрээсийн авлага 40,202.2 мянган төгрөг, НДС-аас авах авлага 7,446.2 мянган төгрөг, хувь хүмүүсээс авах авлага 26,281.9 мянган төгрөг зэрэг нийт 73,930.4 мянган төгрөгийн авлага толилуулсан нь Нягтлан бодох бүртгэлийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нийт 73,930.4 мянган төгрөгийн авлагаас 47,648.5 мянган төгрөгийн авлагыг аудитын явцад тулган баталгаажуулсан ба хувь хүмүүсээс авах 26,281.9 мянган төгрөгийн авлагыг Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь "Төсвийн захирагч нь төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаж шаардлагатай гэж үзэж авлага үүсгэхгүй байх, авлагыг бүрэн барагдуулах талаар менежментийн захидлаар аудитын зөвлөмж өгөх;

### 2.9.4 Өр төлбөрийн талаар

НДЕГ-ын удирдлага 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд ажиллагсадтай холбогдсон өглөг 9,561.7 мянган төгрөг, бусад өглөг 11,467.0 мянган төгрөг зэрэг нийт 17,191.9 мянган төгрөгийн өр төлбөрийг толилуулсан нь Нягтлан бодох бүртгэлийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь "Төсвийн захирагч нь төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэж заасныг хэрэгжүүлэн ажиллаж өр төлбөр үүсгэхгүй байх, үүссэн өр төлбөрийг бүрэн барагдуулах талаар менежментийн захидлаар аудитын зөвлөмж өгөх;

### 2.9.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар

НДЕГ-ын Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь 2009 онд боловсруулагдан батлагдсан бөгөөд түүнээс хойш нэмэлт өөрчлөлт ороогүй, өнөөгийн хэрэгцээ шаардлагыг хангахгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-т "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-т "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана" гэж заасныг хэрэгжүүлэн ажиллах талаар менежментийн захидлаар аудитын зөвлөмж өгөх;

### 2.9.6 БҮТЭЗ-ийн зардлын талаар

НДЕГ-ын удирдлага 2017 оны 03 дугаар сарын 03 өдөр төлөөлөгчдийн бэлэг дурсгалын зүйлс худалдан авахад зориулж БҮТЭЗ-ийн зардлаас 1,208.5 мянган төгрөг зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэж заасныг хэрэгжүүлэн ажиллах талаар менежментийн захидлаар аудитын зөвлөмж өгөх;

### 2.9.7 Цалингийн зардлын талаар

НДЕГ-ын ажилтан Са.Отгон нь тайлант онд 1 ч өдөр ажилдаа ирээгүй нь хурууны хээгээр цаг бүртгэдэг системээс хэвлэсэн баримт, цалингийн хүснэгтээр нотлогдож байхад НДЕГ-ын удирдлага Са.Отгонд тайлант онд 3,852.3 мянган төгрөгийн цалин олгосон нь Хөдөлмөрийн тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1-д "Ажилтны цалин хөлсийг хийснээр, цагаар, бусад хэлбэрээр хөдөлмөрийн үр дүнд нь тохируулан олгоно" гэж заасантай нийцэхгүй байна.



Шийдвэрлэсэн нь: Хөдөлмөрийн тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1-д "Ажилтны цалин хөлсийг хийснээр, цагаар, бусад хэлбэрээр хөдөлмөрийн үр дүнд нь тохируулан олгоно" гэж заасныг хэрэгжүүлэн ажиллах, дээрх зөрчлийг дахин давтан гаргахгүй байх талаар НДЕГ-ын удирдлагад албан шаардлага хүргүүлэх;

### 2.9.8 Орлогын талаар

НДЕГ нь тайлант онд Швейцарийн хөгжлийн агентлагийн 32,916.8 мянган төгрөгийн санхүүжилтээр "Тогтвортой бичил уурхай сургалтыг" зохион байгуулсан боловч уг мөнгөн хөрөнгийг санхүүгийн тайланд толилуулаагүй, зөвхөн нэмэлт санхүүжилтийн дансаар оруулан зарцуулсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ:...14.4.5.бүх орлого; 14.4.6.бүх зардал;" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ:...14.4.5.бүх орлого; 14.4.6.бүх зардал;" гэж заасныг хэрэгжүүлэн ажиллах талаар менежментийн захидлаар аудитын зөвлөмж хүргүүлэх;

### 2.9.9 Томилолтын зардлын талаар

Тайлант онд ХБНГУ-д ажилласан томилолтын зардлаас 4,742.4 мянган төгрөгийн анхан шатны баримтын бүрдэл дутуу байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасныг хэрэгжүүлэн ажиллах талаар менежментийн захидлаар аудитын зөвлөмж өгөх;

### 2.10 АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 344 дүгээр "Агентлаг байгуулах тухай" тогтоолоор Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрыг байгуулснаар ЭМНДЕГ /хуучин бүтцээр/-аас эрүүл мэндийн даатгалын үйл ажиллагааг салгасан байна. Одоогоор санхүүгийн тайлангаас ЭМДЕГ-руу барилга болон бусад хамааралтай хөрөнгийг шилжүүлээгүй байна.

### 2.11 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АСУУДЛУУД

Дараагийн аудитаар ЭМДЕГ-руу шилжүүлсэн хөрөнгийг нягталж авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.


Мөн НДЕГ-ын төлөвлөгөөнд өөрийн орлогыг 86,334.4 мянган төгрөгөөр төлөвлөсөн ба гүйцэтгэлээр 839.0 мянган төгрөг байна. Энэ талаар НДЕГ-ын удирдлагаас тодруулахад системийн хэмжээний орлогын төлөвлөгөөг НДЕГ-ын төсөвт тусган Сангийн яамнаас баталсан бөгөөд системийн хэмжээгээр өөрийн орлого давж биелсэн, төсвийн ерөнхийлөн захирагчийн тайланд тусгагдана гэсэн тайлбарыг өгсөн болно. Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны санхүүгийн тайлангийн аудитаар өөрийн орлогыг гүйцээн шалгаж, төсвийн төлөвлөлтийг оновчтой болгох талаар аудитын зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

### 2.12 Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл

Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 102,422.4 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн ба 2 албан шаардлага хүргүүлж, 98,570.1 мянган төгрөгийн зөрчилд 7 зөвлөмж өгсөн.

### 2.13 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2016 жилийн эцсийн санхүүгийн тайланг УАГ-аас баталгаажуулж, аудитын дүнгээр 3 зөвлөмж өгснийг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.





#### **2.14 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР:**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээс санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгов.

Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2017 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 3,560,126.8 мянган төгрөгийн 2.0 хувиар буюу 71,202.5 мянган төгрөгөөр гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлыг шинэчлэн тодорхойлж, баталгаажууллаа.

#### **2.15 САНАЛ ДҮГНЭЛТИЙН ХЭЛБЭР, ҮНДЭСЛЭЛ**

Бид Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан төсвийн гүйцэтгэлийг баталгаажуулах ажлыг Аудитын олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2017 оны санхүүгийн тайлангийн аудитаар 71,202.5 мянган төгрөгийн материаллаг байдлын түвшинг тогтоосон бөгөөд илэрсэн нийт алдаа нь 48,534.6 мянган төгрөг буюу материаллаг байдлын түвшингөөс даваагүй болно.

Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн байна гэж дүгнэн “Зөрчилгүй” санал дүгнэлт гаргалаа.



### 3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Үндэсний аудитын газар аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгчид зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүүгийн хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг билээ.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт болон аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан.

Энэ нь Нийгмийн даатгалын ерөнхий газрын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан санхүүгийн ажилтнуудад талархал илэрхийлье.

Менежментийн захидалд дурдсан зөвлөмжүүд цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг ач холбогдлынх нь дарааллаар эрэмбэлэн дор нэгтгэн харуулав.



### 3.1 ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЛААР

### Тэргүүлэх ач холбогдол №1

#### ҮАГ-ын ажиглалт

НДЕГ нь тайлант онд 3,031,361.0 мянган төгрөгийн зарлагын батлагдсан төсөвтэйгөөс 2,928,560.2 мянган төгрөгийг зарцуулж батлагдсан төсвийг нийт дүнгээр нь хэтрүүлээгүй боловч цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлыг 647.6 мянган төгрөгөөр, гэрэл цахилгааны зардлыг 399.1 мянган төгрөгөөр, түлш халаалтын зардлыг 967.4 мянган төгрөгөөр, бичиг хэргийн зардлыг 2,246.6 мянган төгрөгөөр, БҮТЭЗ-ийн зардлыг 3,890.2 мянган төгрөгөөр, урсгал засварын зардлыг 8,077.7 мянган төгрөгөөр тус тус хэтрүүлэн зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэж заасантай нийцэхгүй байна.

#### Эрсдэлүүд

Төсвийн тухай хуулийн заалт зөрчигдөж, төсвийн хөрөнгийн зарцуулалтын үр ашиг буурах;

#### ҮАГ-ын зөвлөмж

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэж заасныг хэрэгжүүлэн ажиллаж батлагдсан төсвийн ангиллыг хэтрүүлэхгүй байх;

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 06 дугаар сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

#### Төсвийн захирагчийн хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.



### 3.2 Авлагын талаар

### Тэргүүлэх ач холбогдол №1

#### ҮАГ-ын ажиглалт

НДЕГ-ын удирдлага 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд түрээсийн авлага 40,202.2 мянган төгрөг, НДС-аас авах авлага 7,446.2 мянган төгрөг, хувь хүмүүсээс авах авлага 26,281.9 мянган төгрөг зэрэг нийт 73,930.4 мянган төгрөгийн авлага толилуулсан нь Нягтлан бодох бүртгэлийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасантай нийцэхгүй байна.

#### Эрсдэлүүд

Төсвийн тухай хуулийн заалт зөрчигдөж, төсвийн хөрөнгийн зарцуулалтын үр ашиг буурах;

#### ҮАГ-ын зөвлөмж

Нийт 73,930.4 мянган төгрөгийн авлагаас 47,648.5 мянган төгрөгийн авлагыг аудитын явцад тулган баталгаажуулсан ба хувь хүмүүсээс авах 26,281.9 мянган төгрөгийн авлагыг Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь "Төсвийн захирагч нь төсвийг зохистой удирдаж авлага, ер төлбөр үүсгэхгүй байх" гэж заасныг хэрэгжүүлж ажиллах шаардлагатай гэж үзэж авлага үүсгэхгүй байх, авлагыг бүрэн барагдуулах;

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 06 дугаар сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

#### Төсвийн захирагчийн хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.



**3.3 ӨР ТӨЛБӨРИЙН ТАЛААР**

**Тэргүүлэх ач холбогдол №1**

**ҮАГ-ын ажиглалт**

НДЕГ-ын удирдлага 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд ажиллагсадтай холбогдсон өглөг 9,561.7 мянган төгрөг, бусад өглөг 11,467.0 мянган төгрөг зэрэг нийт 17,191.9 мянган төгрөгийн өр төлбөрийг толилуулсан нь Нягтлан бодох бүртгэлийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасантай нийцэхгүй байна.

**ҮАГ-ын зөвлөмж**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь "Төсвийн захирагч нь төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэж заасныг хэрэгжүүлэн ажиллаж өр төлбөр үүсгэхгүй байх, үүссэн өр төлбөрийг бүрэн барагдуулах;

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 06 дугаар сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

**Эрсдэлүүд**

Төсвийн тухай хуулийн заалт зөрчигдөж, төсвийн хөрөнгийн зарцуулалтын үр ашиг буурах;

**Төсвийн захирагчийн хариу**

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.



**3.4 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын  
баримт бичгийн талаар**

**Тэргүүлэх ач холбогдол №1**

**ҮАГ-ын ажиглалт**

НДЕГ-ын Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь 2009 онд боловсруулагдан батлагдсан бөгөөд түүнээс хойш нэмэлт өөрчлөлт ороогүй, өнөөгийн хэрэгцээ шаардлагыг хангахгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-т “Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана” гэж заасантай нийцэхгүй байна.

**Эрсдэлүүд**

Төсвийн тухай хуулийн заалт зөрчигдөж, төсвийн хөрөнгийн зарцуулалтын үр ашиг буурах;


**ҮАГ-ын зөвлөмж**

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-т “Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана” гэж заасныг хэрэгжүүлэн ажиллаж, өөрийн бие даасан НБББББ-ийг боловсруулан баталж мөрдөн ажиллах;

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 06 дугаар сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

**Төсвийн захирагчийн хариу**

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.





**3.5 БҮТЭЭ-ийн зардлын талаар**

**Тэргүүлэх ач холбогдол №1**

